



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 561

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө дуудлагын худалдаагаар
худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, "Мэдээ, тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Татварын ерөнхий газрын харьяа Сонгинохайрхан дүүргийн татварын хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ өртгөө нөхсөн 9,985,000.00 (есөн сая есөн зуун наян таван мянга) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Татварын ерөнхий газрын дарга Б.Заяабал, Сонгинохайрхан дүүргийн Татварын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Базар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Ажлын хэсэг томилон үндсэн хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу компанийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу холбогдох зардлыг хассан дүнгээр улсын төсвийн дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Худалдсан автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлэн, арга хэмжээний биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан холбогдох мэдээ, тайлангийн маягтын хамт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.Доржсүрэн

Д.НАРАНГЭРЭЛ

132006910

Төрийн өмчийн бодлого,
зохицуулалтын газрын 2021 оны 12
дугаар сарын 02-ны өдрийн
дугаар тогтоолын хавсралт 561

Сонгинохайрхан дүүргийн Татварын хэлтсийн үндсэн хөрөнгөд
бүртгэлтэй, нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах хөрөнгийн
жагсаалт

№	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн ашиглалтад орсон он	Балансын үнэ, Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Худалдах доод үнэ /төгрөг/
1	Тоёота королла маркийн, 36-09 УНО улсын дугаартай, суудлын автомашин, арлын дугаар- NZE1210131392	2002/2011	9,985,000.00	3,500,000.00
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		9,985,000.00 (есөн сая есөн зуун наян таван мянга)	3,500,000.00 (гурван сая таван зуун мянга)